



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр, Даваа гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-4</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>5-8</i>
<hr/>	
<i>Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа</i>	<i>5-8</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 02-ны өдөр /Даваа гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 52 гишүүн хүрэлцэн ирж, 71.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Дэлгэрсайхан, Ц.Сэргэлэн.

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нээлтийн  
ажиллагаа**

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ оролцов.

Танхимын зүүн талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, зөвлөх О.Номинчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын дэд дарга Ц.Батбаатар, Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Я.Баттогтох, Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал Ц.Цогзолмаа, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга А.Энхзул, Цахим парламент, инновацын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Тамир, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга С.Зоригт, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны дарга Б.Энхмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Пүрэвдагва, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга Б.Батманлай, Олон нийттэй харилцах хэлтсийн дарга Б.Энх-Ундрам, Мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Лхагвадорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн;

Танхимын баруун талд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Соёлын сайд Ч.Номин, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар, Монгол Улсын Ерөнхий

аудитор Д.Занданбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам;

Танхимын дээд лоожид Монгол Улсад суугаа гадаад орнуудын Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нар суудлаа эзэлсэн байв.

Танхимын баруун хойд болон зүүн хойд дэлгэцнээ “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ НЭЭЛТ 2023.10.02” гэсэн бичиг гарч байв.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогчид босож хүндэтгэл үзүүлэв.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчдөд талархал илэрхийлж, нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

*Нээлтийн ажиллагаа 10 цаг 14 минутад өндөрлөв.*

Чуулганы нээлтийн ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын студи болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагын зураглаач, гэрэл зурагчид сурвалжлав.

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 13 минут үргэлжилж, 73 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 91.8 хувийн ирцтэйгээр 10 цаг 14 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 01 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг танилцуулъя. 52 гишүүн хүрэлцэн ирж, 71,2 хувьтайгаар ирц бүрдсэн байна. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нээлтийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Үндсэн хуулийн цэцийн дарга, Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Засгийн газрын гишүүд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга бусад төрийн өндөр албан тушаалтнууд, Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагууд болон Нийслэлийн удирдлагууд мөн Монгол Улсаас, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчдийн газар болон Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчдийн газруудын тэргүүн нар оролцож байна. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган эхлэхэд бэлэн болсон байна.

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч, эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, хатагтай, ноёд оо,

Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье. Улсын Их Хурлын энэ удаагийн бүрэн эрхийн отгон намрын чуулган эхэлж байна. Нийгмийн бухимдал өндөр, сонгуулийн идэвхжил эхэлсэн, иргэдийн хүлээлт ихсэж, намрын их ажил ундарсан, өвөлжилтийн бэлтгэл хангагдах өндөр хэмнэлттэй цаг үед энэ чуулган эхэлж байна. Монголын улс төр уламжлал шинэчлэлийн зааг үеэ туулж байна. Үндсэн хууль бол Монголын ардчиллын тулгуур багана учир Үндсэн

хуулийн өөрчлөлт, сонгуулийн шинэ тогтолцоо, Улс төрийн намын шинэ хууль, улс төрийн цоо шинэ уур амьсгал, итгэл, хүлээлт дор Монгол хүн бүр ирээдүйдээ итгэл найдвар тавин хүлээж байна.

Үндсэн хуулийн нэмэлт бүрэн цогц хэрэгжих ёстой. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүрэн цогцоор нь амилуулах ёстой. Тогтолцооны өөрчлөлт шинэчлэлийн үзэл санаа органик процессын хууль болж амьдралд хэрэгжих нь чухал байна. Олон хуулиуд цаасан дээр үлдээд байна. Ингэхээр цаасан дээр үлдэх төдий биш нийгэмд нийт тогтолцоонд бодит өөрчлөлт авчрах ёстой. Хуучинсаг, хөшүүн, хаалттай, нууцтай, дүлий төр ард үлдэж, эсрэгээрээ нээлттэй, хурдтай, ил тод, ард түмэнтэйгээ ямагт хамт байдаг хүчтэй төрийг төлөвшүүлэхийг иргэд дуу нэгтгэн шаардаж байна. Энэ шаардлагын дагуу Улсын Их Хурал шуурхай, мэдрэмжтэй ажиллах, иргэдийн засаглах, мэдэх, хянах, хариуцлага тооцох оролцооны эрхүүдийг баталгаажуулсан олон хууль тогтоомжийг баталсан.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр дамжуулан иргэдийн мэдэх эрхийг хангах зорилготой парламентын хяналт шалгалтын эрхийг өргөтгөсөн. Хянан шалгах түр хороо, Нийтийн сонсгол зэрэг ард түмний хяналт оролцооны эрхийг хуулиар баталгаажуулсан. Одоо иргэдийн бухимдлыг төрүүлсэн элдэв булхай луйврыг төрийн эрх барих дээд байгууллага, ард түмний төлөөлөгчдийн байгууллага ард түмэнтэйгээ хамтран хянан шалгах бүрэн эрхтэй болсныг та бид тууштай хэрэгжүүлэх ёстой. Босоо хэлбэртэй байсан хариуцлагын тогтолцоо хэвтээ болж, ард иргэд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хамтарсан хяналт, оролцоо ардчилал, ил тод байдал дээр тулгуурладаг болсон. Үүнийг одоо бүх шатад ойлгож хэрэгжүүлбэл зохино. Ард түмний оролцоо бол энэ ардчиллын хэвтээ хяналтын тогтолцооны үндэс суурь юм.

Ардчиллын манлайлагч С.Зоригийн Монгол хүний саруул ухаанд би итгэдэг гэж өгүүлсэнчлэн Улсын Их Хурлын гишүүд маань ард иргэдийнхээ чин хүсэл зоригийг мэдэрч ажиллах ёстой. Худал хуурмаг, хулгай луйвар 5 алхалгүй танигдаж, илчлэгддэг болжээ. Хууль зөрчсөн, ард түмнийхээ боломжийг хулгайлсан үйлдлүүдэд хуулийн хариуцлага тооцож, төрийн бодлого нь иргэдийнхээ хүсэлт шаардлагад нийцэж ажиллах хэрэгтэй байна. Ингээж чадахгүй бол төр иргэний итгэлцэл алдарна. Монголын төр засаг авлига, хээл хахуультай тууштайгаар тэмцээр байгаа ч үр дүн нь өргөс авсан мэт түргэн гарахгүй байна. Хөгжлийг гацааж, хувиа бодсон цөөн хэсгийн шуналт үйлдлийн үр дагавар өнөөдөр Монгол төрийн нэр хүндийг удаанаар тогтвортой унагаж, баллуурдаж байна.

Тиймээс Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг авлигын эсрэг тэмцэлтэй сэтгэл зориг нэгтэйгээр тууштай зүтгэхийг хүсэж байна. Засгийн газрын энэ хүчин чармайлтыг бид дэмжиж ажиллах учиртай. Яг энэ цаг үед нийгмийн бухимдлыг дээд цэгт нь хүргээд байгаа Нийслэл хотод 30 гаруй жил ужгирсан асуудлуудыг шалгаж шийдэмгий шуурхай арга хэмжээ авах нь чухал байна. Энэ зорилгоор Улсын Их Хурлын хяналт шалгалтын түр хороог яаралтай зохион байгуулж, газрын наймаа, нийтийн тээвэр, дулаан, цахилгааны тусгай зөвшөөрөл, төрийн худалдан авалтыг тойрсон авлига хээл хахуулийн асуудлыг ил тод болгож, хариуцлага тооцох ёстой гэж үзэж байна. Эрхэм гишүүд, Улсын Их Хурал дахь Нийслэлийн хөгжлийн түр хороо, холбогдох Байнгын хороод, намын бүлгүүд үүн дээр онцгойлон анхаарч ажиллахыг үүрэг чиглэл болгож байна. Монголд төр сахилга, хариуцлагын гүн хажуудалд орсон гэж ард иргэд дүгнэж байна.

Та бид өнгөрсөн хаврын чуулганыг Авлигын эсрэг чуулган гэж зарлаж, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг

баталсан. Монголын эдийн засагт үлэмж хэмжээний хохирол учруулсан нүүрсний гэх тодотголтой хэргийн сонсголыг нэн тэргүүнд зохион байгуулахыг иргэд та бид нараас шаардаж байна. Тиймээс хаврын чуулганыг авлигын эсрэг тэмцэх эрхэм зорилгоор энэ чуулган ч үргэлжлүүлэх шаардлагатай байна. Шүүх байгуулах тухай хуулиас эхлээд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай зэрэг хуулиудыг баталж, эрх зүйн шинэчлэлээ гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Шүүхийн тухай хуулийн зарим заалт тухайлбал шүүх тогтолцооны гажуудлыг засах чиглэлээр тодорхой заалтууд хэрэгжихгүй байгаа тайлбараа Улсын Их Хуралд ирүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шаардаж байна. Сахилга, хариуцлагын талаар гажуудсан ойлголтыг нэг мөр засах хариуцлагын цогц шинэчлэлийг хийх цаг болжээ. Авлигын суурь шалтгаан болох төрийн данхар эрх мэдлийг хумьж, эдийн засагт оролцоог нь эрс багасгах бодит хэрэгцээ шаардлага хойшлуулиггүй болсон байна.

Бизнес болон эдийн засгийн чухал салбаруудыг дэмжсэн Баялаг бүтээгчдийг дэмжих багц хуулийг яаравчлан батлуулахаар Улсын Их Хурал ажиллаж байгаа. Мөн уул уурхай дагасан, хэт уул уурхайн эд хамааралтай эдийн засгийг цөөнхийн эдийн засгийн эрх мэдлийг хумих, нээлттэй компани болгох, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, эдийн засгийн бусад салбаруудыг дэмжих, үндэсний үйлдвэрлэлээр дэмжих, мал аж ахуйн орон гэдгээ сэргээж, олонхын оролцоог дэмжсэн, уламжлалт ахуйдаа суурилсан томоохон хөтөлбөрийг хэрэгжүүлэх зайлиггүй шаардлага тулгараад байна. Бид задралаас нэгдэл рүү шилжих түүхэн бодит боломж энэ шийдэлд байна. Монгол Улсын мал өсөх тусам малчингүй, бэлчээргүй, цөлжсөн, үр ашиггүй, үржил шимгүй, эсрэгээрээ хор хөнөөл нь нөхөж байхгүй хэмжээнд хүрэх хачирхалтай гажуудалд автагдаад байна гэж дэлхийн дулаарлын талаар дүгнэж байгаа гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид дүгнэж байна.



Япончууд технологи бол бидний хөгжил гэж тодорхойлоод төлөвлөгөөт төрийн зохицуулалтаар хэрэгжүүлсэн бол Израилчууд хөдөө аж ахуйн хөгжлийнх нь боломж, хөдөө аж ахуйн хөгжлийнх нь боломж гэж хараад хоёулаа өндөр хөгжсөн шиг Монголчууд бид ухдаг баялгийн нөөцөө ашиглан ургуулдаг баялгийн салбар буюу хөдөө аж ахуйн салбараа босгох цаг иржээ. Энэ бидэнд тийм ч хол салбар биш юм. Ийм учраас Засгийн газраас хэрэгжүүлж эхлээд байгаа Хот, хөдөөгийн сэргэлт энэ хөтөлбөр төслийг Хөдөө аж ахуйн сэргэлт, хөдөөгийн сэргэлттэй уялдуулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бид бас дандаа саар биш олон сайн үзэгдлийн эхлэл дээр байна. Эдийн засаг тэлж, экспорт түүхэн дээд хэмжээндээ хүрч, валютын нөөц 4 тэрбум долларыг давлаа. Дотоодын нийт бүтээгдэхүүн 1 хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5 мянган долларт хүрсэн нь авлигатай хийх тэмцлийн бодит үр дүн гэдэгт эргэлзэх хэрэггүй. Хязгаарлалт гацаа саадуудыг оношлон зассанаар тун ойрын жилүүдэд бид эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн гэрч болох болно гэдэгтээ итгэлтэй байж болох ёстой. Бид шинэ тогтолцооны анхны сонгуулиа хийх нүсэр бэлтгэлийг базаах болно. Цоо шинэ олон сорилтууд биднийг хүлээж байна. Гэхдээ алдаан дээрээ суралцаж, сайжруулсан бидний хамтын зүтгэл талаар өнгөрөх ёсгүй. Ардчилал алдаан дээрээ суралцах тусмаа улам төгөлдөрших, төлөвших ёстой. Улс төрийн шинэ соёл хандлага тогтож, Монгол Улсын хөгжил дэвшлийг хурдасгагч хүч болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Цар тахал, дайны дараалсан он жилүүдэд манай улсын гадаад харилцааны бодлого төв тэгш байгааг дурдах ёстой. Олон сорилт шалгуурт бид хөрш орнууд болон эх дэлхийдээ энх тайвныг баримтлагч улс гэдгээ тогтвортой тунхагласаар байна. Эрэлт сэргээж, эрс идэвхэжсэн гадаад харилцааны олон чухал айлчлалууд

үргэлжилж Монгол Улсад маань түүхэн боломжууд шинээр бий болсоор байгааг энд дурдах нь зүйтэй байх. Гадаад ертөнцөд хүйтэрсэн уур амьсгал дотоод талдаа илүү дулаан байхыг та биднээс шаардаж байгааг хүн бүр ойлгож байгаа буй за.

Намрын чуулганы нэг томоохон ажил бол улсын төсвийг хэлэлцэн батлах явдал юм. Энэ жилийн төсөв сонгуулийн жилийн төсөв болохгүй байх тал дээр онцгойлон анхаарахыг эрхэм гишүүд та бүхнийг онцгойлон анхаараасай гэж хүсэж байна. Эрсдэлт нөхцөл байдал дуусаагүй энэ цаг үед болзошгүй тооцоололд бэлэн байх нь та бидний үүрэг. Тиймээс улсын төсвийг батлах хэлэлцүүлэгт туйлын хариуцлагатай хандахыг уриалж байна. Анх удаа төсвийн хэлэлцүүлгийн өмнө Монгол Улсын Ерөнхий сайд бүх аймаг орон нутагт ажиллаж, иргэдийн оролцоотой төсвийн хэлэлцүүлгийн эхлэлийг тавьсан. Одоо энэ төсвийн хэлэлцүүлгээ бид үр дүнтэй, бодитой болгож, сайн төсөв батлахад анхаарах ёстой.

Эцэст нь Монголын нийгэм амьд хэв шинжээр сайн тал руугаа өөрчлөгдөж байна. Иргэдийн оролцоо идэвхжиж, шүгэл үлээгчид олирон, нийгмээрээ буруу булхайгаа шүүн хэлэлцэж, худал хуурмагт орон зай үлдээлгүй шахаж байна. Ардчиллын сайн тал, ил тод байдлын үр дүн бол энэ. Гэхдээ бид бас орчин үеийн технологийн 4 дүгээр хувьсгалын үед нөлөөлж байгаа сөрөг нөлөөллийг ч гэсэн бид мартаж учиргүй. Энэ бүхнийг нэгтгэн харвал хөгжих үндэстний амьд сайн шинж яах аргагүй мөн юм байгаа юм. Цаашид та бидний шүүмжлэл, үл ойлголцол дундуур хэлэлцэн баталсан олон хууль цаг хугацааны шалгуурт тодрон хэрэгжиж, Монголын хөгжлийн хурдасгуур болно гэдэгт бүрэн итгэлтэй байна. Нийгэмд оюун санааны хөгжил, өөрчлөлт хурдацтай явагдаж, буруугаа дүгнэж, зөвөө чиглэж буй энэ түүхэн цаг үед эрхэм гишүүд та бүхний саруул ухаан, мэргэн шийдвэр, онч бодлого, зөвийн төлөөх зориг шийдэлд тань итгэж байна.



*Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,*

*Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы ажиллагаа нээснийг мэдэгдье.*

*Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд оролцсон хүндэт зочид, төлөөлөгчид та бүхэнд баярлалаа. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье. Одоо Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Дараа нь намын бүлгүүд хуралдана.*

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**БУУЛГАЖ, ХЯНАСАН:**

**ШИНЖЭЭЧ**

**Д.УЯНГА**